

БАТЛАВ:

БАТЛАВ:

ХӨРӨНГӨ ОРУУЛЖ, ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2014 оны 9 дүгээр сарын
...-ны өдөр

№

Улаанбаатар
хот

Энэхүү ХӨРӨНГӨ ОРУУЛЖ, ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ (цаашид “Гэрээ” гэх)-ийг

Нэг талаас _____ хаягт оршин суух, _____
регистрийн дугаартай _____ -ийн _____ /Цаашид “А
тал” гэх/;

Нөгөө талаас _____ хаягт албан ёсоор байрлах,
Монгол улсын хуулийн этгээд болох _____ ХХК /Цаашид
“Б тал” гэх/, түүнийг төлөөлж _____ -ийн _____ нар
харилцан амлалт, тохиролцоог үндэс болгон дараах нөхцөлөөр энэхүү
гэрээг байгуулав.

**Нэг. Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан
хууль, эрх зүйн үндэслэл.**

- 1.1 Энэхүү Хөрөнгө оруулж, хамтран ажиллах гэрээг талууд Монгол Улсын иргэний хуулийн 48 дугаар бүлэг, Хөрөнгө оруулалтын тухай хууль болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгон байгуулав.

**Хоёр. Хөрөнгө оруулалтын зорилго,
үндсэн үйл ажиллагаа.**

- 2.1 Энэхүү гэрээг байгуулсан талуудын хамтын үйл ажиллагааны зорилго (үндсэн үйл ажиллагаа) нь талууд хуулийн этгээд байгуулахгүйгээр ашиг олох зорилгыг хэрэгжүүлэхэд оршино.
- 2.2 Талуудын хөрөнгө оруулалтын зорилго нь талууд энэхүү гэрээний 3.1.1, 3.1.2-д заасан хөрөнгийг
..... Б тал нь хөрөнгө оруулалт хийж, тухайн газар дээр барилгын норм, дүрэм, стандарт шаардлагад нийцсэн үйлчилгээ, зочид буудлын зориулалттай, зоорийн давхарын хамт нийт 20 давхар барилга барих, энэхүү гэрээгээр тохирсон хэмжээгээр барилгыг хуваан эзэмшихтэй холбоотой үүсэх аливаа харилцааг зохицуулна.
- 2.3 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар, зохих ёсоор биелүүлэх бөгөөд Монгол Улсын хууль тогтоомжийг сахин биелүүлэх үүрэг хүлээнэ.
- 2.4 Хамтын ажиллагаа нь эрх тэгш, харилцан ашигтай байх зарчим дээр суурилна.
- 2.5 Энэ гэрээнд заасан үндсэн үйл ажиллагаанд туслах чиг үүрэг бүхий харилцаанд энэ гэрээний холбогдох зарчим нөхцлийг хэрэглэж болно.
- 2.6 Талууд өөрсдийн үйл ажиллагаатай холбоотой гэрээ, хэлцлийг шинэчлэн байгуулах, дангаар гаргасан саналаа ажил хэрэг болгох зэрэг тохиолдолд харилцан зөвшөөрлийг авах замаар шийдвэрлэнэ.
- 2.7 Гэрээний талууд нь энэхүү гэрээгээр зохицуулж буй үйл ажиллагаанд хамаарахгүй өөр төрлийн бизнесийн болон бусад үйл ажиллагааг хамтран эрхлэх тохиолдолд энэ гэрээ нь үйлчлэхгүй бөгөөд уг харилцааг шинээр гэрээ байгуулах замаар зохицуулна.

**Гурав. Хөрөнгө оруулалтын төрөл, хувь хэмжээ,
талуудын эзэмших хувь хэмжээ**

3.1. Хөрөнгө оруулалтын төрөл, хэмжээ

3.1.1. А тал нь дараах хэлбэрээр хөрөнгө оруулна.

3.1.1.1.;

3.1.2. Б тал нь дараах хэлбэрээр хөрөнгө оруулна.

3.1.2.1.

санхүүжилтийг мөнгөн болон эд хөрөнгийн хэлбэрээр оруулна.

3.2. Талуудын эзэмших хувь, хэмжээ

3.2.1. А тал нь эрх бүхий байгууллагаас батлагдсан,

.....захиран зарцуулах эрхтэй болно.

3.2.2. Б тал нь

..... өмчлөх эрхийг хүлээн авч, захиран зарцуулах эрх эдэлнэ.

Дөрөв. Баталгаа, мэдэгдэл

4.1. Б тал нь дараах баталгаа мэдэгдлийг А талд гаргаж байна.

4.1.1. Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээд мөн болно.

4.1.2. Энэхүү гэрээг төлөөлөн гарын үсэг зурж буй этгээд нь компанийг гуравдагч этгээдийн өмнө төлөөлөх бүрэн эрх бүхий этгээд мөн болно.

4.1.3. Энэхүү гэрээний зорилготой холбоотой үйл ажиллагааг санхүүжүүлэх бодит боломж, санхүүгийн чадвартай болно.

4.2. А тал нь дараах баталгаа, мэдэгдлийг Б талд гаргаж байна.

4.2.1. А тал нь угэзэмших, ашиглах эрх бүхий цорын ганц этгээд мөн болно.

4.2.2. эрхийг хуулийн дагуу олж авсан бөгөөд уг газартай холбоотойгоор гуравдагч этгээдийн нэхэмжлэл, маргаан байхгүй, шүүх арбитрын ажиллагаа байхгүй болно.

4.2.3. А тал нь нөгөө талын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр гэрээний эрх, үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэх эрхгүй.

4.2.4. А тал нь энэхүү гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэх зайлшгүй шаардлагатай гэж үзэн хүсэлт гарган мөн газрын эзэмших эрхээ бусдад шилжүүлэх тохиолдолд Б тал гэрээний эрх үүргийг өөрийн эзэмшилд авах давуу эрхийг эдэлнэ.

4.3. Гэрээнд заасан талуудын өөрийн овог, нэр /хуулийн этгээдийн оноосон нэр, төлөөлөх эрх бүхий албан тушаалтны овог, нэр/болон хаяг өөрчлөгдсөн тохиолдолд энэ тухайгаа нөгөө талдаа ажлын 3 хоногийн дотор бичгээр мэдэгдэх үүрэгтэй бөгөөд ийнхүү мэдэгдээгүйн улмаас учирсан хохирол, үр дагаварыг буруутай тал бүрэн хариуцна.



Гэрээний төсөл нь төлбөртэй татагдах тул бүрэн эхээр нь татахыг хүсвэл 77052494, 80802494 утсаар холбогдоно уу.